



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах зарим арга
хэмжээний тухай

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 19 дэх заалтыг зөрчин байр талбайг аж ахуйн нэгж, иргэнд түрээслүүлсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчиж 588.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн, зэрэг зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Удирдах Зөвлөл /Б.Баатарзориг/-д дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, шалгалтын мөрөөр зохион байгуулах ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулах;

2.2. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн захирал /Д.Мандах/-д дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

3.2 Тухайн жилийн үр дүн, орлого, зардлын төлөвлөгөөг эдийн засгийн тооцоо судалгаатай төлөвлөж батлуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;


3.2.Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр үндсэн хөрөнгө бэлтгэж байгааг цаашид таслан зогсоох;

3.4. Сургуулийн илүүдэлтэй байр талбайг бусдад түрээслэхдээ Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ыг мөрдөх.

00001/9

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 08 дугаар сарын 05-ний өдрийн
40 дугаар тогтоолын хавсралт

“Монгол Улсын Боловсролын Их Сургууль”-ийн шалгалтаар
илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Үнийн дүн /Сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 14 дүгээр зүйлийн 4, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчиж үндсэн хөрөнгө зөвшөөрөлгүй олж авсан	Захирал, Санхүү, эдийн засгийн газрын дарга, холбогдох ажиллагсад	588.6	Үндсэн хөрөнгө олж авахад зөвшөөрөл авах
2	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 19 дэх заалтыг зөрчиж байр талбай түрээсэлсэн	Захирал, Санхүү, эдийн засгийн газрын дарга, холбогдох ажиллагсад		Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 19 дэх заалтыг мөрдөж ажиллах
Зөрчил, дутагдлын нийт дүн			588.6	